

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	Нэр Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Жаргалсайхан Хунан
2	Хүсэлт гаргагчийн хаяг Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	Төрсөн огноо Төрсөн газар	
4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	1999-2006 Еөтвөш Лорандын нэрэмжит шинжлэх ухааны их сургууль – төр, эрх зүйн ухааны бакалавр, магистр 1987-1997 Монгол-Оросын хамтарсан 3-р сургууль - Бүрэн дунд
5	Ажил эрхлэлт Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<ul style="list-style-type: none"> - Монголын Хуульчдын холбоо, ЧД, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 403, 7011-6364, www.mglbar.mn, Ерөнхийлөгч - Нээлттэй нийгэм форум, СБД, Жамъян гүний гудамж 5/1, 313207, www.forum.mn, Эрх зүйн чадавхийг дээшлүүлэх нь төслийн Зөвлөх - “Партнерс фореввер” ХХК, ЧД, Бага тойруу 5/2, 70104066, хуульч - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, СБД, Нэгдсэн үндэстний гудамж 14, 327585, www.mn.undp.org, “Эрх зүйн чадавхийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах нь” төсөл, “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх” төслийн зохицуулагч - ХЗДХЯ, ЧД, Засгийн газрын V байр, Худалдааны гудамж 6/1, 267533, www.mojha.gov.mn, мэргэжилтэн
6	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн

7	<p>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. 	<p>1. 2017-2019 - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, ЧД, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 403, 2 жил - Ажлын байрны тодорхойлолт; 1.Хуульчдын холбооны зөвлөлтэй зөвшилцөн Хуульчдын их хурлыг зарлан хуралдуулах; 2.Хуульчдын холбооны зөвлөлийн хуралдааныг даргалах; 3.Хуульчдын холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх; 4.Хуульчдын холбооны зөвлөлд Хуульчдын холбооны тамгын газрын даргад нэр дэвшүүлэх; 5.ХЭЗБТ хуулийн 61 дүгээр зүйлд заасан Хуульчдын холбооны шүүгчдийн хорооны удирдах зөвлөлөөс өргөн мэдүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс сонгож, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгох. 6.ХЭЗБТ хуулиар болон Хуульчдын холбооны дүрмээр олгосон бусад бүрэн эрх. - Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл: Хуульчдын их хурал</p> <p>2. 2016-2017 - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Монголын Хуульчдын холбооны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсин дарга, ЧД, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 403, 1 жил 9 сар - Ажлын байрны тодорхойлолт; Ижил төрлийн гадаад, дотоодын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, Уулзалт, семинар зохион байгуулах, Ерөнхийлөгч, Тамгын даргад орчуулга хийж өгөх, Холбооны бичиг баримтыг орчуулах</p> <p>3. 2016-2017 - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Нээлттэй нийгэм форумын Эрх зүйн чадавхийг дээшлүүлэх нь төслийн Зөвлөх, СБД, Жамъян гүний гудамж 5/1, 1 жил 7 сар - Ажлын байрны тодорхойлолт; Хамтрагч байгууллагуудтай уулзалт хийх, сургалт, семинар зохион байгуулах, төслийн хүрээнд хийгдэх судалгааны удирдамж боловсруулахад дэмжлэг үзүүлэх, судалгааны явцад хяналт тавих, цахим хөтөчийн агуулга, загварыг гаргах</p> <p>4. 2013-2016 - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Партнерс Фореввер ХХК-ийн хуульч, ЧД, Бага тойруу 5/2, 3 жил - Ажлын байрны тодорхойлолт; Компанийн бичиг, баримт боловсруулах, төсөл бичих, судалгаа хийх, хуулийн зөвлөгөө өгөх, шүүхэд төлөөлөл хэрэгжүүлэх, үйлчлүүлэгчтэй харилцах, хуулийн санал дүгнэлт боловсруулах, хамтрагч байгууллагуудтай уулзалт хийх, сургалт, семинар зохион байгуулах.</p>
---	---	---

		<p>5. 2011-2013</p> <p>- Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: НҮБХХ-ийн “Эрх зүйн чадавхийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах нь” төслийн зохицуулагч, ЧД, Нэгдсэн Үндэстний гудамж 14, 1 жил 6 сар</p> <p>- Ажлын байрны тодорхойлолт; Төслийг амжилттай хэрэгжүүлэх, хүссэн үр дүнг гаргах, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хамтрагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, жилийн төсөв, төлөвлөгөө, тайлан боловсруулах,</p> <p>6. 2007-2011</p> <p>- Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: НҮБХХ-ийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх” төслийн зохицуулагч” төслийн зохицуулагч, ЧД, Нэгдсэн Үндэстний гудамж 14, 4 жил</p> <p>- Ажлын байрны тодорхойлолт; Төслийг амжилттай хэрэгжүүлэх, хүссэн үр дүнг гаргах, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хамтрагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, жилийн төсөв, төлөвлөгөө, тайлан боловсруулах,</p> <p>7. 2005-2007</p> <p>- Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газар, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ажлын албанд тус тус мэргэжилтэн, ЧД, Засгийн газрын V байр, Худалдааны гудамж 6/1, 2 жил 6 сар</p> <p>- Ажлын байрны тодорхойлолт; Газар, хэлтсийн чиг үүргийн хүрээнд баримт бичиг, албан бичгийн төсөл, санал боловсруулах, уулзалт зохион байгуулах, гэрээ, хэлцэл орчуулах, сургалт зохион байгуулж, судалгаа хийх.</p>
8	<p>Ёс зүй Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно. -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.</p>	Байхгүй
9	<p>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн</p>	1. Монголын Хуульчдын холбооны гадаад харилцаа шинэ түвшинд гарсан: 2017 онд Хуульчдын холбооны Ерөнхийлөгчөөр сонгогдож өөрийн бодлогын тэргүүлэх чиглэлээр Монголын хуульчдын чадавхийг нэмэгдүүлэх гэж тодорхойлсон. Энэ хүрээнд гадаад улсын ижил төрлийн байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулах,

<p>сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. 	<p>хамтран сургалт семинар зохион байгуулах, олон улсын шинж чанартай арга хэмжээнд Монгол Хуульчдыг илтгэл хэлэлцүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулсан. 2016 онд Ази номхон далайн бүсийн Хуульчдын холбоодын Ерөнхийлөгч нарын дээд хэмжээний уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан, Олон улсын барын холбооны шагналыг Монгол хуульч хүртсэн, Ази-Номхон далайн бүсийн Хуульчдын холбооны ээлжит 33 дугаар чуулга уулзалт 2020 онд Монгол Улсад зохион байгуулагдах болсон, Хуульчдын холбоо олон улсын түвшинд ч тэр, бүс нутгийн хэмжээнд ч тэр идэвхтэй болсон зэрэг үр дүн гарсан. Түүнчлэн ОХУ-ын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Өмнөд Солонгос улсын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Гонк-конгийн хуульчдын нийгэмлэгийн Ерөнхийлөгч, Киргиз улсын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь хуульчдын гадаад харилцаа, холбоонд эергээр нөлөөлсөн гэж үзэж байна. Энэ бүгдийг өөрийн мэдлэг, туршлагад үндэслэн амжилттай зохион байгуулж чадсан.</p> <p>2. Азийн сантай хамтран хуулийн салбарын шударга байдлын судалгааг хийсэн</p> <p>Судалгааны ажлын хүрээнд шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, авилгатай тэмцэх газрын албан хаагч, нотариатч, арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн байдлыг судласан. Анх удаагаа хуулийн байгууллагын албан хаагчид бусдаддаа үнэлгээ өгсөнөөрөө онцлог юм. Судалгааны үр дүнд байгууллагууд алдаа оноогоо засах, үйлчилгээний чанараа сайжруулах боломжтой болсон гэж үзэж байгаа.</p> <p>3. Нээлттэй нийгэм форумтай хамтран “Эрүүгийн хууль тогтоомжин хэрэгжилт, тулгамдаж буй асуудал сэдэвт” цуврал хэлэлцүүлэг</p> <p>Монголын Хуульчдын холбоо нь Нээлттэй нийгэм форумтай хамтран Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хэд хэдэн удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тухайлбал, тавдугаар сард бүх талын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн тулгамдаж буй асуудлуудыг практик түвшинд ярилцаж, “Хуулийн шүүмж” эмхэтгэлийг хэвлүүлж гаргасан.</p> <p>4. Цахим хөтөчийн аппликэйшн. Энэхүү аппликэйшныг бүтээлгэснээр иргэд өөрсдийн гар утаснаасаа хууль зүйн зөвлөгөө, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авах боломжтой болсон. Мөн түүнчлэн ахисан шатны туслалцаа шаардлагатай бол өмгөөлөгчтэй холбогдох боломжийг нээж өгсөн байдаг.</p> <p>5. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр. 2016 оны Засгийн газрын хөтөлбөрт бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ туссан байдаг. Нээлттэй нийгэм форумын төслийн зөвлөхийн хувьд хөтөлбөрийн үндэс суурь болсон судалгааг улсын хэмжээнд зохион байгуулах, судалгааны удирдамж боловсруулах ажилд зөвлөж хяналт тавьж ажилласан. Үндсэндээ судалгааны үр дүн, хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн цахим хөтөчийн тогтолцоо бүрэлдсэн. Иргэд өөрт шаардлагатай анхан шатны зөвлөгөөг цахимаар хүссэн мэдэллээ, хүссэн газраас авах боломжтой болсон.</p> <p>6. “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо” судалгааны ажил. Нээлттэй нийгэм хүрээлэнгээс зарласан судалгааны ажилд залуу хуульчдын хамт оролцож улсын хэмжээний судалгаа хийж гүйцэтгэсэн. Хүний эрхийг</p>
--	---

	<p>хамгаалах хамгийн том баталгаа бол хараат бус шүүх, шүүгч. Судалгааны үр дүн, зөвлөмжүүд хожим Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт болон шүүгчийн хараат бус байдалд хамаар хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг.</p> <p>7. Төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний механизм. Хүний эрхийг хангха үндэсний хөтөлбөрийг хүрээнд Төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх Засгийн газрын хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрт зааснаар бүх аймаг, дүүрэгт эрх зүйн туслалцааны төв байгуулахаар тусгасан байдаг. Эдгээр эрх зүйн туслалцааны төвүүдийг бүрэн байгуулж үйл ажиллагаа нь жигдэртэл буюу төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль батлагдах хүртэл Хүний эрхийн төслийн зүгээс санхүү болон арга зүйн хувьд дэмжиж ажилласан. Эрх зүйн туслалцааны төвүүдтэй холбоотой дүрэм журам боловсруулах, гадна туршлага судлуулах, сургалт зохион байгуулах гээд цогч ажлын үр дүнд өнөөдрийг хууль зүйн туслалцааны механизм бүрдсэн гэж хэлж болно.</p> <p>8. Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо. Хүний эрхийн төслийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийн гэрч, хохирогчийг зайлшгүй хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага байгааг судалгаагаар тодорхойлсон бөгөөд ХЗДХЯ дээр Ажлын хэсэг байгуулж, гадаад улсын туршлага судлах, хуулийн төслийг боловсруулсан. Хожим хуулийн төслийг баталж гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн байдаг.</p> <p>9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенци. Хүний эрхийн төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэж орохыг уриалсан цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг байсан. Үүний нэг “ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооё” уриатай парадыг 2 жил дарааллан зохион байгуулсан бөгөөд үр дүнд нь конвенцид Монгол Улс нэгдэж орсон ба төрийн үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэх нөхцөл боломж бүрдэж эхэлсэн.</p> <p>10. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид Засгийн газрын илтгэл бичих журмын шинэчлэл. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенцийг хэрэгжилтийн тайлан илтгэл явуулах ажил ойлгомжгүй, аль байгууллага хариуцаж зардал гаргах нь тодорхойгүйгээс тайлан илтгэл явуулах хугацааг хожимдуулдаг, гэрээгээ хүлээсэн үүргээ биелүүлддэггүй байсан. Хүний эрхийн төслийн хүрээнд Засгийн газрын илтгэл бичих журмыг шинэчилж, илтгэл бичих үүрэг, зардлыг тодорхой болгосноор илтгэл хугацаандаа явах нөхцөл бүрдсэн.</p> <p>11. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг шүүхэд хэрэглэсэн байдлын судалгаа. Энэхүү судалгааг 2008 онд МУИС-ийн ХЗС-ийн багш М.Мөнхбаттай хамтран хийсэн бөгөөд анх удаагаа олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг шүүхэд хэрэглэсэн байдлыг судалсан болно. Судалгааны үр дүнд шүүгч, хуульчдад олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг хэрхэн хэрэглэх талаар сургалт, семинар явуулсан байдаг.</p> <p>12. УЕПГ-ын газар, МУИС-ийн ХЗС, Монголын Хуульчдын холбоо хамтран “Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь” сэдэвт онол-практикийн хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 14-нд зохион байгуулсан. Миний бие уг хэлэлцүүлгийг нээж үг хэлсэн бөгөөд “Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хууль бол Үндсэн</p>
--	--

		<p>хуулийн дараа ордог хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдалд хамаарах хамгийн чухал хуулиуд байдаг. Эдгээр хуулиуд нь шударга ёс хэрхэн хэрэгжиж байгааг хэмжих нэг хэрэгсэл нь болдог. Тиймээс бид шинэчлэл хийгээд удаагүй байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудтай холбоотой засаж сайжруулах шаардлагатай, зүйлүүдийг хуульчид, судлаачид, практикт ажиллаж хүмүүсийн дунд хэлэлцүүлэх нь маш чухал” гэдгийг онцлон тэмдэглэсэн.</p>
<p>10</p>	<p>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</p>	<p>1. Хуульчдын пробоно өдөрлөгийг тэмдэглэдэг болсон Хуульчдын нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрийг Хуульчдын про боно өдөрлөг болгож зарласан. Ингэснээр улсын хэмжээнд хуулийн бүх байгууллагууд нэгдсэн байдлаар иргэдэд нэг өдөр үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгч, эрх зүйн чадавхийг дээшлүүлэх ажилд хувь нэмэр оруулдаг болсон.</p> <p>2. Хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт заавал үзэж судлах хичээлээр хүний эрхийн хичээлийг оруулсан. Өмнө Хуульчийн заавар үзэх хичээлийн төрөлд Үндсэн хуулийн эрх зүй, Хуульчийн ёс зүй байсан бол 2019 оноос Хүний эрх болж нэмэгдсэнээр хуульчдын хүний эрхийн талаарх мэдлэг нэмэгдэнэ. Түүнчлэн Хуульчдын холбооны уриаг Хүний эрх, шударга ёс, тогтортой хөгжил болгож, хүний эрх гэдэг нэр томъёог хуульчдын заавал хэрэглэх нэр томъёо болгоход дэм болсон гэж үзэж байна.</p> <p>3. “Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын өнгөрсөн, одоо, ирээдүй” онол практикийн бага хурлыг өнөөдөр 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Монголын Хуульчдын холбоо, “Эмнести интернэшнл” байгууллага, МУИС-ийн Хууль зүйн сургууль хамтран зохион байгуулсан. Хүний эрхийн боловсролын асуудалд бүх нийтийн анхаарлыг хандуулах, Монгол Улсад дэлхийн хүний эрхийн боловсролын НҮБ-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг онол, практикийн түвшинд судлах, цаашид сайжруулах арга замыг санал болгон зөвлөмж гаргах зорилготойгоор зохион байгуулсан. “Албан бус боловсролоор хүний эрхийн боловсрол олгож буй нь” хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр миний бие ажилласан.</p> <p>4. "Хүний эрхийн соёлыг бэхжүүлэх нь" симпозиумыг 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Гадаад харилцааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улсын их сургууль, Монголын Хуульчдын холбоо, Монголын Эмнести интернэшнл байгууллага хамтран зохион байгуулсан. Энэхүү симпозиумын хүрээнд орчин үеийн хүний эрхийн хөгжил, чиг хандлага, үзэл баримтлал, хүний эрхийн боловсрол, соёлыг үнэлэх нь, хүний эрхийн боловсролын заах арга зүй, сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, сайн туршлага, хүний эрхийн боловсрол нийгмийн хөгжил дэвшилд, хүний эрхийн уулзварт тогтвортой бизнес эрхлэх нь, мэдээллийн технологийг хүний эрхийн боловсролд ашиглаж буй сайн туршлага, ололт амжилт зэрэг сэдвийг 9 салбар хуралдаанаар хэлэлцүүлж, Хүний эрхийн боловсролын талаарх хамтын байр суурийн баримт бичиг, Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний зураглал, зөвлөмжийг гаргасан.</p> <p>5. Хот дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын болон орон нутгийн хэмжээнд иргэдийн газар, эд хөрөнгө өмчлөх эрхийг хангах, шаардлагад нийцсэн</p>

	<p>орон байраар хангагдах эрхийн зөрчлийг бууруулах, таслан зогсооход хувь нэмэр оруулах зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын Холбоо, Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургууль, Монголын Эмнести Интернэшнл байгууллага хамтран 2019 оны тавдугаар сарын 08-ны өдөр “Хот төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх” сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>6. Хүний эрхийн үндэсний комисс, Нээлттэй нийгэм форум хамтран зохион байгуулдаг хүний эрхийн цуврал лекцийн хүрээнд "Технологи-хөгжил-хүний эрх" сэдвээр 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр лекц уншсан</p> <p>7. “Бизнес ба Хүний эрх” зөвлөлдөх уулзалтад Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч хувиар оролцож “Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх механизмын хүртээмж” сэдэвт хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр ажилласан ба “Хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах нь дан ганц төр-иргэн, иргэн-иргэн харилцаанд бус иргэн-бизнес эрхлэгч харилцаанд мөн адил үйлчилж, хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, түүнд хяналт тавих, зөрчигдсөн эрхийг сэргээх төрийн болон төрийн бус үр дүнтэй механизмыг бий болгох нь чухал. Уулзалтын үеэр гарсан санал, зөвлөмжүүд Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгалаа олж бодитоор хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байна” гэдэг асуудлыг хөндөж гаргасан.</p> <p>8. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенци. Хүний эрхийн төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэж орохыг уриалсан цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг байсан. Үүний нэг “ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооё” уриатай парадиг 2 жил дарааллан зохион байгуулсан бөгөөд үр дүнд нь конвенцид Монгол Улс нэгдэж орсон ба төрийн үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэх нөхцөл боломж бүрдэж эхэлсэн.</p> <p>9. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг шүүхэд хэрэглэсэн байдлын судалгаа. Энэхүү судалгааг 2008 онд МУИС-ийн ХЗС-ийн багш М.Мөнхбаттай хамтран хийсэн бөгөөд анх удаагаа олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг шүүхэд хэрэглэсэн байдлыг судалсан болно. Судалгааны үр дүнд шүүгч, хуульчдад олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг хэрхэн хэрэглэх талаар сургалт, семинар явуулсан байдаг.</p> <p>10. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 60 жилийн ойг угтан зохион байгуулсан Хүний эрхийн фестиваль, “Эрхүүлэй” үндэсний баатар төрүүлсэн. Хүний эрхийн төслийн хүрээнд зохион байгуулсан уг арга хэмжээ нь анх удаагаа зохион байгуулагдсанаар онцлог байсан бөгөөд хүний эрхийн талаар өргөн хүрээнд сургалт сурталчилгаа явуулсан цогц арга хэмжээ байсан. Залуучуудад хүний эрхийн талаар мэдлэг олгох залуучуудын бүтээсэн “Эрхүүлэй” баатрыг олон таниулж орон нутагт ЕБС-ийн хүүхдүүдэд сургалт явуулсан.</p> <p>11. Хүний эрхийн төслийн хүрээнд Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төвүүдийг нээсэн. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төвүүдийг Гэмтлийн эмнэлэг, Шүүх эмнэлэг, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн байгуулсан. Эдгээр төвүүдэд хохирогчид олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үнэ төлбөргүй авдаг байсан.</p> <p>12. Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хөдөлмөрлөх эрхийг хангах, хамгаалах хүрээнд бичил төсөл хэрэгжүүлсэн. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын</p>
--	---

		<p>Монгол Улс дахь салбартай хамтран хөдөлмөрлөх эрхийг хангах, хамгаалах чиглэлээр албадан хөдөлмөрийн устгахад чиглэсэн судалгаа, сурталчилгаа, сургалтыг хуульчдад зохион байгуулсан.</p> <p>13. Нээлттэй нийгэм форум, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх www.legalaid.mglbar.mn цахим хуудас бүтээж иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө авах боломжийг олгосон.</p>
11	<p>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<p>1. Хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт заавал үзэж судлах хичээлээр хүний эрхийн хичээлийг оруулсан. Өмнө Хуульчийн заавар үзэх хичээлийн төрөлд Үндсэн хуулийн эрх зүй, Хуульчийн ёс зүй байсан бол 2019 оноос Хүний эрх болж нэмэгдсэнээр хуульчдын хүний эрхийн талаарх мэдлэг нэмэгдэнэ. Түүнчлэн Хуульчдын холбооны уриаг Хүний эрх, шударга ёс, тогтортой хөгжил болгож, хүний эрх гэдэг нэр томъёог хуульчдын заавал хэрэглэх нэр томъёо болгоход дэм болсон гэж үзэж байна.</p> <p>2. "Хүний эрхийн соёлыг бэхжүүлэх нь" симпозиумыг 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Гадаад харилцааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улсын их сургууль, Монголын Хуульчдын холбоо, Монголын Эмнести интернэшнл байгууллага хамтран зохион байгуулсан. Энэхүү симпозиумын хүрээнд орчин үеийн хүний эрхийн хөгжил, чиг хандлага, үзэл баримтлал, хүний эрхийн боловсрол, соёлыг үнэлэх нь, хүний эрхийн боловсролын заах арга зүй, сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, сайн туршлага, хүний эрхийн боловсрол нийгмийн хөгжил дэвшилд, хүний эрхийн уулзварт тогтвортой бизнес эрхлэх нь, мэдээллийн технологийг хүний эрхийн боловсролд ашиглаж буй сайн туршлага, ололт амжилт зэрэг сэдвийг 9 салбар хуралдаанаар хэлэлцүүлж, Хүний эрхийн боловсролын талаарх хамтын байр суурийн баримт бичиг, Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний зураглал, зөвлөмжийг гаргасан.</p> <p>3. Төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний механизм. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хүрээнд Төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх Засгийн газрын хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрт зааснаар бүх аймаг, дүүрэгт эрх зүйн туслалцааны төв байгуулахаар тусгасан байдаг. Эдгээр эрх зүйн туслалцааны төвүүдийг бүрэн байгуулж үйл ажиллагаа нь жигдэртэл буюу төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль батлагдах хүртэл Хүний эрхийн төслийн зүгээс санхүү болон арга зүйн хувьд дэмжиж ажилласан. Эрх зүйн туслалцааны төвүүдтэй холбоотой дүрэм журам боловсруулах, гадна туршлага судлуулах, сургалт зохион байгуулах гээд цогц ажлын үр дүнд өнөөдрийг хууль зүйн туслалцааны механизм бүрдсэн гэж хэлж болно.</p> <p>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенци. Хүний эрхийн төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэж орохыг уриалсан цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг байсан. Үүний нэг "ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооё" уриатай парадыг 2 жил дарааллан зохион байгуулсан бөгөөд үр дүнд нь конвенцид Монгол Улс нэгдэж орсон ба төрийн үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэх нөхцөл боломж</p>

		<p>бүрдэж эхэлсэн.</p> <p>5. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид Засгийн газрын илтгэл бичих журмын шинэчлэл. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенцийг хэрэгжилтийн тайлан илтгэл явуулах ажил ойлгомжгүй, аль байгууллага хариуцаж зардал гаргах нь тодорхойгүйгээс тайлан илтгэл явуулах хугацааг хожимдуулдаг, гэрээгээ хүлээсэн үүргээ биелүүлддэггүй байсан. Хүний эрхийн төслийн хүрээнд Засгийн газрын илтгэл бичих журмыг шинэчилж, илтгэл бичих үүрэг, зардлыг тодорхой болгосноор илтгэл хугацаандаа явах нөхцөл бүрдсэн.</p> <p>6. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 60 жилийн ойг угтан зохион байгуулсан Хүний эрхийн фестиваль, “Эрхүүлэй” үндэсний баатар төрүүлсэн. Хүний эрхийн төслийн хүрээнд зохион байгуулсан уг арга хэмжээ нь анх удаагаа зохион байгуулагдсанаар онцлог байсан бөгөөд хүний эрхийн талаар өргөн хүрээнд сургалт сурталчилгаа явуулсан цогц арга хэмжээ байсан. Залуучуудад хүний эрхийн талаар мэдлэг олгох залуучуудын бүтээсэн “Эрхүүлэй” баатрыг олон таниулж орон нутагт ЕБС-ийн хүүхдүүдэд сургалт явуулсан.</p> <p>7. Хүний эрхийн төслийн хүрээнд Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төвүүдийг нээсэн. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төвүүдийг Гэмтлийн эмнэлэг, Шүүх эмнэлэг, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн байгуулсан. Эдгээр төвүүдэд хохирогчид олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үнэ төлбөргүй авдаг байсан.</p> <p>8. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг шүүхэд хэрэглэсэн байдлын судалгаа. Энэхүү судалгааг 2008 онд МУИС-ийн ХЗС-ийн багш М.Мөнхбаттай хамтран хийсэн бөгөөд анх удаагаа олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг шүүхэд хэрэглэсэн байдлыг судалсан болно. Судалгааны үр дүнд шүүгч, хуульчдад олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг хэрхэн хэрэглэх талаар сургалт, семинар явуулсан байдаг.</p> <p>9. Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо. Хүний эрхийн төслийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийн гэрч, хохирогчийг зайлшгүй хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага байгааг судалгаагаар тодорхойлсон бөгөөд ХЗДХЯ дээр Ажлын хэсэг байгуулж, гадаад улсын туршлага судлах, хуулийн төслийг боловсруулсан. Хожим хуулийн төслийг баталж гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн байдаг.</p> <p>10. “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо” судалгааны ажил. Нээлттэй нийгэм хүрээлэнгээс зарласан судалгааны ажилд залуу хуульчдын хамт оролцож улсын хэмжээний судалгаа хийж гүйцэтгэсэн. Хүний эрхийг хамгаалах хамгийн том баталгаа бол хараат бус шүүх, шүүгч. Судалгааны үр дүн, зөвлөмжүүд хожим Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт болон шүүгчийн хараат бус байдалд хамаар хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг.</p>
12	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан</p>	

	<p>шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл <p>Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</p>	
13	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ. 	<p>Олон улсын хуульчдын холбоо 2013 Эвлэрүүлэн зуучлах хороо 2014 Монголын Хуульчдын холбоо 2013 Монголын өмгөөлөгчдийн холбоо 2010 Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал эрхэлсэн хороо 2015</p>
14	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, 	<p>Бүтээл Чингис хааны төр, эрх зүйн түүх /реферат/ 2002 Олон улсын эрх зүй /орчуулга/ 2005 Хууль зүйн туслалаа авах эрх /нийтлэл/ 2009</p> <p>Судалгааны ажил: Шүүхийн хараат бус байдал 2006 Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг шүүхэд хэрэглэх нь 2008 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлж буй хууль зүйн үйлчилгээний хүртээмж 2008 Хууль зүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн тогтолцоо 2009 Хөдөлмөрлөх эрхийг хэрэгжилт 2010</p>

<p>хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<p>Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо 2010 Эрх зүйн чадавхийн судалгаа 2011 Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо 2015 Иргэдийн эрх зүйн чадавхийн өнөөгийн байдал 2016 Төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөгч томилж байгаа байдал 2016</p> <p>Хууль тогтоомжийн төсөл боловсруулсан туршлага, оролцсон ажил: Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлт боловсруулах ажил Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах ажил Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн төсөл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн төсөл</p> <p>2017.12.25-Ж.Хунан-Зууны мэдээ 2018.08.25-newspress 2018.11.30-Хуульч-ньус-Ярилцлага 2019.09.04-Өглөөний сонин</p>
---	---

--- оОо ---